БАТЛАВ
БАЯНГОЛ ШИНЭ ӨРГӨӨ ОНӨААТҮГЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ж ГАЛТБАЯР

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Баянгол дүүргийн хэмжээнд хог хаягдлын тээвэрлэлт, нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ, тохижилтын ажил гүйцэтгэхэд шаардагдах хог тээврийн туслан гүйцэтгэгч байгууллагаар ажил гүйцэтгүүлэх нь дараах шаардлагыг хангасан байна.

2. Баянгол Шинэ Өргөө ОНӨААТҮГ-т төсөвт өртөгт багтаан түрээсээр ажиллуулах хог тээврийн үйлчилгээний автомашин болон туслан гүйцэтгэх ажил үйлчилгээний техникийн шаардлага хангасан тээврийн хэрэгсэл байна. Автомашин нь дараах техникийн үзүүлэлт, шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжээс, шаардлага, шалгуур үзүүлэлтүүд
1	Нэр төрөл, хийц, загвар	Хог хаягдал нягтруулан шахдаг
2	Зориулалт	Аюулгүй хог хаягдал тээвэрлэх
3	Даац, кг	25000-30000 (MNS 4598:2003)
4	Үйлдвэрлэсэн он, техникийн байдал	2020 оны сүүлийн жил, түүнээс хойш
5	Овор (урт х өргөн х өндөр) мм	8235 x 2490 x 3250 (илүүгүй)
6	Тэвшний хийц	Арагшаа буудаг битүү
7	Клиренс, мм	270 (багагүй)
8	Эргэх тойрог, м	20 (илүүгүй)
9	Хөдөлгүүрийн чадал, м.х., стандарт	120-150 (багагүй), Euro-2 plus
10	Тэвшний хэмжээ, (урт х өргөн х өндөр) мм	4800 x 2000 x 1800 (ойролцоогоор)
11	Шалны зузаан, мм	16
12	Хананы зузаан, мм	12
13	Өргөх механизм	Гидро систем-шахах
14	Дугуй хэмжээс	12.00R, 320-508P, 20PR
15	Нэмэлт шаардлага	Аюулгүй ажиллагааг хангаж ухрахын камертай байна. Гэрэл багатай үед ажиллах боломжтой байлгахаар нэмэлт гэрэлээр тоноглосон байна.
16	Бүхээгний тоноглол	3 суудал, ардаа ортой, аерокондишн, хаалга, цонх, шил, тольны цахилгаан удирдлагатай

3. Автомашины үндсэн болон нэмэлт тоноглол нь Монгол улсын MNS 4598:2003 "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавигдах ерөнхий шаардлага" стандартын заавал мөрдөгдөх үзүүлэлт, шаардлагыг хангасан байна.

4. Түрээсээр ажиллуулах шахдаг техникийн шаардлагыг тогтоохдоо дараах үзүүлэлтийн тооцож үзсэн болно.

- Хогийн цэгийн ачих, буулгах талбайн замын эргэлт, өгсүүр
- Ачих хог хаягдлын шинж чанар
- Ачих буулгах машин, механизмын үзүүлэлт
- Алсын зайд тээвэр гүйцэтгэх боломж, замын даац

5. Түрээсээр ашиглах шахдаг тээврийн хэрэгсэл нь ажлын шаардлага хангасан байх бөгөөд зайлшгүй шаардлагатай түлхүүр, багаж хэрэгсэл, ашиглалтын заавар бэлэн байна.

6. Техникийн тодорхойлолтод заасан техникийн шаардлагуудыг бүрэн хангасан эсэхийг бараа хүлээн авах үед хамтран шалгах ба шинэ бараа байна. (шаардлагад нийцээгүй бол татгалзах үндэслэл болно)

7. Барааг Баянгол дүүрэг 20-р хороо, Сонсголонгийн зам Г/40-5, Үйлдвэрийн баруун бүс, Өөрийн байр, авто баазын хашаанд аюулгүй байдлыг ханган нийлүүлнэ.

ХЯНАСАН:
ДОТООД ХЯНАЛТЫН
АЖИЛТАН Г.ДАВААСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:
АВТОБААЗ ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА С.НЯМЛХАГВА